



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/34


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3, 3.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийг арчлах, мод, сөөг, зүлэг нөхөн болон шинээр тарих, орон сууц, гэр хороолол дотор бичил цэцэрлэг байгуулах ажилд агротехнологийн хяналт тавьж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх, зөрчил дутагдлыг арилгах үүрэг бүхий Төрийн бус байгууллагуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 02 сарын 12-ны
өдрийн 2/34 тушаалын хавсралт



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга :	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Нааяа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн
	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн Шуурхай ажил хариуцсан Ахлах мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Улаанбаатар хот. Сүхбаатар дүүргийн 3-р хороо. 24-р байр. 39 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн дарга:	бичгийн Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ногоон байгууламжийн арчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн